



ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2020 оны 02 сарын 21 өдөр

Дугаар 8/15

Улаанбаатар хот

Г Заавар батлах тухай Г

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 02 дугаар сарын 13-ны 62 дугаар тогтоолын 3 дахь заалт, Улсын онцгой комиссын хурлын 05 дугаар тэмдэглэлийн 2.2 дугаар заалт, Улсын онцгой комиссын даргын 2020 оны 02 сарын 13-ны өдрийн 04 дүгээр тушаалын 8 дахь заалт, 2017 оны А/161 дүгээр тушаалын хоёрдугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Коронавируст (КОВИД-19) халдвартын үед халдвартгүйжүүлэлт хийх түр зааврыг хавсралтаар баталсугай.
2. Коронавируст (КОВИД-19) халдвараас сэргийлэх ажлыг эрчимжүүлэх ажлын хүрээнд нийтийн тээврийн үйлчилгээний байгууллага, авиакомпани, нийтийн үйлчилгээний газар, дэлгүүр, супермаркет, зах, худалдааны төв, сууц өмчлөгчдийн холбоо, өрх гэрт уг зааврыг дагаж мөрдөнө.
3. Энэхүү тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллах, мэргэжил арга зүйн зөвлөгөөг тогтмол өгч ажиллахыг алба, тасгийн дарга, эрхлэгч нар болон аймаг, нийслэлийн Зоонозын өвчин судлалын төвүүдийн дарга наарт тус тус даалгасугай.
4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дэд захирал /Б.Амгаланбаяр/-т үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ Н.ЦОГБАДРАХ





Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн ерөнхий захирлын 2020 оны 10 дугаар сарын 21 - ны өдрийн 15 дугаар тушаалтын хавсралт

TT35150-9092005

КОРОНАВИРУСТ (COVID-19) ХАЛДВАРЫН ҮЕД ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭЛТ ХИЙХ ТУХАЙ ТҮР ЗААВАР

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү зааврыг шалган нэвтрүүлэх пост, нийтийн тээврийн үйлчилгээний байгууллага, авиа компани, нийтийн үйлчилгээний газар, дэлгүүр, супер маркет, хүнсний зах, худалдааны төв, сууц өмчлөгчдийн холбоо, өрх гэрт дагаж мөрдөнө.

Хоёр. Нийтлэг зүйл

Өдөр тутмын цэвэрлэгээ, халдвартгүйжүүлэлтийг тогтмол чанартай хийх нь коронавируст (COVID-19) халвар болон бусад халдварт өвчин тархахаас урьдчилан сэргийлэх чухал арга хэмжээ юм.

- 2.1 Коронавируст (COVID-19) халдвараас сэргийлэх өндөржүүлсэн бэлэн байдал зарласантай холбоотой цэвэрлэгээ үйлчилгээ, урьдчилан сэргийлэх халдвартгүйжүүлэлтийг зааврын дагуу хийж гүйцэтгэнэ. Шаардлагатай тохиолдолд эцсийн халдвартгүйжүүлэлтийг мэргэжлийн байгууллагад хандан хийлгэнэ.
- 2.2 Хэрэглэж байгаа бодисууд нь мэргэжлийн байгууллагуудын чанарын баталгаатай, хэрэглэх хугацаа хэтрээгүй, зөв хадгалагдсан хэрэглэх аргачлал тодорхой, хэрэглэх зааварчилгаанд үйлчлэгч болон халдвартгүйжүүлэлт хийх ажилтан сургагдсан байна.
- 2.3 Байнгын цэвэрлэгээ, угаалга, халдвартгүйжүүлэлтийг тухайн байгууллага өдөр бүр, тогтмол давтамжтай хийж тэмдэглэл хөтөлнө.
- 2.4 Хүн бүр хувийн ариун цэвэр сайн сахих, нэг удаагийн маск тогтмол зүүх, маскийг 3 цаг тутамд сольж зориулалтын таглаатай хогийн саванд хаях, бээлий өмсөх, гар халдвартгүйжүүлэх бодисыг тогтмол хэрэглэнэ.

Гурав. Албан байгууллага:

- 3.1. Өдөр тутмын цэвэрлэгээнд үйлчлэгч нарыг ажлын хамгаалах хувцас, амны хаалт, бээлийтэй ажиллах нөхцөлөөр хангасан байна.
- 3.2. Цэвэрлэгээнд хэрэглэгдэх бодисыг найруулж бэлдэх, ашиглах зааварт сургаж, дадлагажуулсан байна
- 3.3. Чийгтэй цэвэрлэгээг өдөрт 3-с доошгүй хийнэ.
- 3.4. Шат, цахилгаан шат, хаалганы бариул, хаалга, ширээ сандал, компьютерийн гар, хулгана, суурин утас гэх мэт хүний гар хүрэх бүх хатуу гадаргууг 0.015%-ийн жавелионы уусмалаар арчих, эсвэл шүршинэ.

- 3.5. Угаалгын өрөөний тосгуур, бенн, суултуурыг 0,03%-ийн жавелионы уусмалаар арчих, эсвэл шүршиж халдвартгүйтгэнэ.
- 3.6. Шүршиж хэрэглэсэн тохиолдолд 1 цаг болсны дараа чийгтэй цэвэрлэгээ хийнэ
- 3.7. Ил задгай жорлон, цооног, бохир ус, хог хаягдалгипохлорит кальци400 гр/л байхаар тооцон хийж халдвартгүйжүүлнэ.
- 3.8. Өрөө тасалгааны цонхыг 2 цаг тутамд нээж агаар сэлгэх

Дөрөв. Нийгмийн халамж үйлчилгээ үзүүлдэг төрийн болон төрийн бус байгууллагууд гэх мэт зайлшгүй төрийн үйлчилгээ үзүүлэх шаардлагатай албан байгууллага:

- 4.1 Төвүүдийн хаалга, шатны бариул, цахилгаан шат, цахилгаан шатны товчлуур зэргийг 3 цаг тутамд арчина.
- 4.2 Тэргэнцэр, шал хана гэх мэт хатуу гадаргууг 0,015%-ийн жавелионы уусмалаар арчих эсвэл шүршинэ. Шүршиж халдвартгүйжүүлэлт хийснээс хойш 1 цагийн дараа чийгтэй цэвэрлэгээ хийнэ.
- 4.3 Төрөл бүрийн тоглоомыг 2%-ийн содын уусмалд угаах эсвэл 0,015%-ийн жавелионы уусмалд 30 минут байлгасны дараа цэвэр усаар сайтар зайлна.
- 4.4 Алчуур, цагаан хэрэглэл,ор дэрний хэрэгсэлийг 0,03%-ийн жавелионы уусмалд 30 минут байлгасны дараа угаана.
- 4.5 Өрөө тасалгаа, орцны цонхыг 2 цаг тутамд нээж агаар сэлгэх

Халдвартгүйтгэлийн бодисын найруулах арга

| № | Халдвартгүйжүүлэх бодисын нэр | Ажлын уусмал | Халдвартгүйтгэлийн бодисын орох хэмжээ | Уусмалын хувь | Халдвартгүйтгэх талбай |
|---|-------------------------------|--------------|--|---------------|---|
| 1 | Клорсепт | 5 л | 1 ш | 0,02% | Шал, хаалганы бариул гэх мэт хатуу гадаргуу |
| | | 2 л | 1 ш | 0.05% | Ариун цэврийн өрөө, угаалтуур, суултуур |
| 2 | Жавелион | 10 л | 1 ш | 0.015% | Шал, хаалганы бариул гэх мэт хатуу гадаргуу |
| | | 10 л | 2 ш | 0,03% | Ариун цэврийн өрөө, угаалтуур, суултуур |
| 3 | Гипохлорид натри /Белезна/ | 9850 мл | 150 мл | 0.25% | Шал, хаалганы бариул гэх мэт хатуу гадаргуу |
| | | 9400 мл | 600 мл | 1% | Ариун цэврийн өрөө, угаалтуур, суултуур |

Тав. Өрх гэрт

- 5.1 Өдөр тутам чийгтэй цэвэрлэгээ хийх, цэвэрлэгээнд зориулалтын ахуйн хэрэглээний бодис хэрэглэнэ.
- 5.2 Хивс болон дэвсгэрийг тоос сорогчоор соруулж, 7 хоногт 1-2 удаа салхинд тавина.
- 5.3 Өрөө тасалгааны цонхыг 2 цаг тутамд нээж, агаар сэлгэх.
- 5.4 Хүүхдийн тоглоомыг 2%-ийн содын уусмалд угааж цэвэр усаар зайлж хатаана.
- 5.5 Хүүхдийг гэрийн тэжээвэр амьтантай тоглуулахгүй байх

- 5.6 Хүн бүр гаднаас орж ирэх, бие засссаны дараа, хоол унд бэлтгэх болон бэлтгэсний дараа, идэхийн өмнө гарыг тогтмол савандаж угаана.
- 5.7 Хоол хүнсийг бүрэн гүйцэт болгож хэрэглэх шаардлагатай
- 5.8 Хоолны хэрэгслэл, аяга, таваг, халбага, сэрээг зориулалтын угаагч шингэн, 2%-ийн содын уусмалд угаах болон 30 минут буцалгана.
- 5.9 Гэр бүлийн гишүүд гадуур явахдаа амны хаалт хэрэглэх, 3 цаг тутам солих, хэрэглэсэн амны хаалтыг зориулалтын таглаатай хогийн саванд хаяна.
- 5.10 Гадуур хувцасыг тогтмол угааж цэвэрлэнэ.
- 5.11 Угаалгын өрөөний тосгуур, суултуурыг 0,03%-ийн жавелионы уусмалаар арчина.
(10 литр усанд 2 ширхэг жавелион хийж 0,03% халдвартгүйжүүлэх уусмалыг бэлтгэх)
- 5.12 Ил задгай жорлон, цооног, бохир ус, хог хаягдалд гипохлорит кальци 400 гр/л байхаар тооцон хийж халдвартгүйжүүлнэ.
- 5.13 Цэвэрлэгээнд хэрэглэсэн алчуур, хувин багаж хэрэгслийг 0,03% халдвартгүйтгэх уусмалд 30 минут байлгасны дараа цэвэр усаар сайтар зайлж хатаана.

Зургаа. Нийтийн орон сууц, орц хонгил, цахилгаан шат, албан байгууллагуудад

- 6.1 Нийтийн орон сууцны шал, орцны хаалга, шатны бариул, цахилгаан шат, цахилгаан шатны товчлуур зэргийг 3 цаг тутамд арчиж цэвэрлэнэ.
- 6.2 Орой бүр оршин суугчдыг амарсны дараа орцны шал хананы нийт гадаргууг 0,015%-ийн жавелионы халдвартгүйжүүлэх уусмалаар арчих эсвэл шүршинэ. Шүршиж халдвартгүйжүүлэлт хийснээс хойш 1 цагийн дараа их цэвэрлэгээ хийнэ.
- 6.3 Орц, хонгилын цонхыг 2 цаг тутамд нээж агаар сэлгэх.
- 6.4 Хариуцсан ажилтан нийтийн хогийг хуваарийн дагуу тогтмол ачуулж цэвэрлэх.

Халдвартгүйтгэлийн бодисын найруулах арга

| № | Халдвартгүйжүүлэх бодисын нэр | Ажлын уусмал | Халдвартгүйтгэлийн бодисын орох хэмжээ | Уусмалын хувь | Халдвартгүйтгэх талбай |
|---|-------------------------------|--------------|--|---------------|---|
| 1 | Клорсепт | 5 л | 1 ш | 0,02% | Шал, хаалганы бариул гэх мэт хатуу гадаргуу |
| | | 2 л | 1 ш | 0.05% | Ариун цэврийн өрөө, угаалтуур, суултуур |
| 2 | Жавелион | 10 л | 1 ш | 0.015% | Шал, хаалганы бариул гэх мэт хатуу гадаргуу |
| | | 10 л | 2 ш | 0,03% | Ариун цэврийн өрөө, угаалтуур, суултуур |
| 3 | Гипохлорид натри /Белезна/ | 9850 мл | 150 мл | 0.25% | Шал, хаалганы бариул гэх мэт хатуу гадаргуу |
| | | 9400 мл | 600 мл | 1% | Ариун цэврийн өрөө, угаалтуур, суултуур |

Долоо. Нийтийн үйлчилгээний газар, дэлгүүр, супермаркет, хүнсний зах, худалдааны төв

- 7.1 Олон нийтийн үйлчилгээний газруудад орох, гарах хаалганы ойролцоо хэсгүүд, хаалганы бариул, шатны бариул, цахилгаан шат, цахилгаан шатны товчлуур, урсдаг шатны бариул зэрэг бохирдол ихтэй үйлчлүүлэгчдийн хамгийн их хүрэлцдэг гадаргууг 3 цаг тутамд арчина.
- 7.2 Цонхыг 2 цаг тутамд нээж агаар сэлгэх.
- 7.3 Өдөр бүр хаасны дараа шал, тааз зэрэг хатуу гадаргууд чийгтэй цэвэрлэгээ хийсний дараа 0.015%-ийн жавелионы уусмалаар арчих эсвэл шүршинэ. Шүршиж халдвартгүйжүүлэлт хийснээс хойш 1 цагийн дараа чийгтэй цэвэрлэгээ хийнэ.
- 7.4 Олон нийтийн газрууд гар халдвартгүйжүүлэх спиртэн суурьтай бодис байршуулсан байна.
- 7.5 Үйлчилгээний төв бүр ажилчид болон үйлчлүүлэгчдийн гар угаах нөхцлийг бүрдүүлсэн байна.

Халдвартгүйтгэлийн бодисын найруулах арга

| № | Халдвартгүйжүүлэх бодисын нэр | Ажлын уусмал | Халдвартгүйтгэлийн бодисын орох хэмжээ | Уусмалын хувь | Халдвартгүйтгэх талбай |
|---|-------------------------------|--------------|--|---------------|---|
| 1 | Клорсепт | 5 л | 1 ш | 0,02% | Шал, хаалганы бариул гэх мэт хатуу гадаргуу |
| | | 2 л | 1 ш | 0.05% | Ариун цэврийн өрөө, угаалтуур, суултуур |
| 2 | Жавелион | 10 л | 1 ш | 0.015% | Шал, хаалганы бариул гэх мэт хатуу гадаргуу |
| | | 10 л | 2 ш | 0,03% | Ариун цэврийн өрөө, угаалтуур, суултуур |
| 3 | Гипохлорид натри /Белезна/ | 9850 мл | 150 мл | 0.25% | Шал, хаалганы бариул гэх мэт хатуу гадаргуу |
| | | 9400 мл | 600 мл | 1% | Ариун цэврийн өрөө, угаалтуур, суултуур |

Найм. Нийтийн хоолны газар

- 8.1 Өдөр тутам хийх цэвэрлэгээ үйлчилгээ, халдвартгүйжүүлэлтийг тогтмол хийнэ.
- 8.2 Аль болох нэг удаагийн хэрэгслийг ашиглана.
- 8.3 Аяга таваг, үйлчилгээний хоолны хэрэгслийг зориулалтын угаагч бодисоор угаахаас гадна 2%-ийн содын уусмалд 30 минут буцалгаж дараа нь цэвэр усаар сайтар зайлна.
- 8.4 Зориулалтын аяга таваг угаах төхөөрөмжийг хэрэглэнэ.
- 8.5 Нийтийн ариун цэврийн өрөө, суултуурыг 0,03%-ийн жавелионы уусмалаар 2 цаг тутам арчиж, халдвартгүйжүүлэн агааржуулалт хийнэ.
- 8.6 Үйлчлүүлэгчид болон ажилчдыг гар угаах болон халдвартгүйжүүлэх нөхцлөөр зайлшгүй хангасан байна.

Халдвартгүйтгэлийн бодисын найруулах арга

| № | Халдвартгүйтгүүлэх бодисын нэр | Ажлын уусмал | Халдвартгүйтгэлийн бодисын орох хэмжээ | Уусмалын хувь | Халдвартгүйтгэх талбай |
|---|--------------------------------|--------------|--|---------------|---|
| 1 | Клорсент | 5 л | 1 ш | 0,02% | Шал, хаалганы бариул гэх мэт хатуу гадаргуу |
| | | 2 л | 1 ш | 0.05% | Ариун цэврийн өрөө, угаалтуур, суултуур |
| 2 | Жавелион | 10 л | 1 ш | 0.015% | Шал, хаалганы бариул гэх мэт хатуу гадаргуу |
| | | 10 л | 2 ш | 0,03% | Ариун цэврийн өрөө, угаалтуур, суултуур |
| 3 | Гипохлорид натри /Белезна/ | 9850 мл | 150 мл | 0.25% | Шал, хаалганы бариул гэх мэт хатуу гадаргуу |
| | | 9400 мл | 600 мл | 1% | Ариун цэврийн өрөө, угаалтуур, суултуур |

Ес. Нийтийн бие засах газар

- 9.1 Нийтийн ариун цэврийн өрөө, суултуурын хэсгийг 2 цаг тутам 0,03%-ийн жавелионы уусмалаар арчих эсвэл шүршинэ. Шүршиж халдвартгүйтгүүлэлт хийснээс хойш 1 цагийн дараа чийгтэй цэвэрлэгээ хийнэ.
- 9.2 Олон нийтийн газруудад гар халдвартгүйтгүүлэх спиртэн сурьтай бодисыг байршуулсан байна.
- 9.3 Үйлчилгээний төв бүрүйлчлүүлэгчид болон ажилчдын гар угаах нөхцлийг бүрдүүлсэн байна.

Халдвартгүйтгэлийн бодисын найруулах арга

| № | Халдвартгүйтгүүлэх бодисын нэр | Ажлын уусмал | Халдвартгүйтгэлийн бодисын орох хэмжээ | Уусмалын хувь | Халдвартгүйтгэх талбай |
|---|--------------------------------|--------------|--|---------------|---|
| 1 | Клорсент | 5 л | 1 ш | 0,02% | Шал, хаалганы бариул гэх мэт хатуу гадаргуу |
| | | 2 л | 1 ш | 0.05% | Ариун цэврийн өрөө, угаалтуур, суултуур |
| 2 | Жавелион | 10 л | 1 ш | 0.015% | Шал, хаалганы бариул гэх мэт хатуу гадаргуу |
| | | 10 л | 2 ш | 0,03% | Ариун цэврийн өрөө, угаалтуур, суултуур |
| 3 | Гипохлорид натри /Белезна/ | 9850 мл | 150 мл | 0.25% | Шал, хаалганы бариул гэх мэт хатуу гадаргуу |
| | | 9400 мл | 600 мл | 1% | Ариун цэврийн өрөө, угаалтуур, суултуур |

Арав. Тээврийн хэрэгсэлд

- 10.1 Нийтийн тээврийн хэрэгсэлд даавуун хөшиг, даавуун суудлын бүрээс хэрэглэхийг хориглоно.
- 10.2 Жолооч нар нэг удаагийн амны хаалт тогтмол зүүж, 3 цаг тутам сольж таглаатай хогийн саванд хаяж, нэгдсэн устгалд оруулна.

- 10.3 Чийгтэй цэвэрлэгээг өдөрт 3-с доошгүй удаа хийнэ.
- 10.4 Тээврийн хэрэгслийн гадна талд дугуй, хаалга, хаалганы бариулыг 0.015%-ийн жавелионы уусмалаар шүршинэ.
- 10.5 Тээврийн хэрэгслийн дотор хэсэг, хана, суудал, шал, хаалганы бариул, жолооны хүрд гэх мэт хүний гар хүрэх бүх гадаргууд 0.015%-ийн жавелионы уусмалаар арчих, эсвэл шүршинэ.
- 10.6 Шүршиж хэрэглэсэн тохиолдолд 1 цаг болсны дараа чийгтэй цэвэрлэгээ хийх
- 10.7 Тойролт бүрийн дараа эцсийн буудал дээр зорчигчид буусны дараа дээрх хэсгийг халдвартгүйтгэлийн уусмалаар арчиж, цонхыг нээж агаар сэлгэлт хийсний дараа зорчигчдыг суулгана.
- 10.8 Тээврийн хэрэгсэлд гар халдвартгүйжүүлэх бодисыг зорчигчид хэрэглэхэд хүрэлцэхүйц хэмжээгээр байрлуулах, хэрэглээнд хяналт тавьж ажиллана.

Халдвартгүйтгэлийн бодисыг найруулах арга

| № | Халдвартгүйжүүлэх бодисын нэр | Ажлын уусмал | Халдвартгүйтгэлийн бодисын орох хэмжээ | Уусмалын хувь | Халдвартгүйтгэх талбай |
|---|-------------------------------|--------------|--|---------------|---|
| 1 | Клорсент | 5 л | 1 ш | 0,02% | Шал, хаалганы бариул гэх мэт хатуу гадаргуу |
| | | 2 л | 1 ш | 0,05% | Ариун цэврийн өрөө, угаалтуур, суултуур |
| 2 | Жавелион | 10 л | 1 ш | 0,015% | Шал, хаалганы бариул гэх мэт хатуу гадаргуу |
| | | 10 л | 2 ш | 0,03% | Ариун цэврийн өрөө, угаалтуур, суултуур |
| 3 | Гипохлорид натри /Белезна/ | 9850 мл | 150 мл | 0,25% | Шал, хаалганы бариул гэх мэт хатуу гадаргуу |
| | | 9400 мл | 600 мл | 1% | Ариун цэврийн өрөө, угаалтуур, суултуур |

Арван нэг. Агаарын хөлөгт

- 11.1 Нисгэгч, нисэх багийн бүрэлдэхүүнд ажиллах ажилчид нэг удаагийн амны хаалт тогтмол зүүж, 3 цаг тутам сольж битүү таглаатай хогийн саванд хаяж устгалд оруулна.
- 11.2 Чийгтэй цэвэрлэгээг өдөрт 3-аас доошгүй удаа хийнэ.
- 11.3 Онгоцны дотор хэсэг, хана, суудал, шал, хаалганы бариул, жолооны улирдлагын хэсэггэх мэт хүний гар хүрэх бүх гадаргуу, дугуй, ачаа тээш хадгалах хэсэг, онгоцны шат, ариун цэврийн өрөө, хогийн сав зэргийг халдвартгүйтгэлийн уусмалаар арчих, эсвэл шүршинэ.
- 11.4 Шүршиж хэрэглэсэн тохиолдолд 1 цаг болсны дараа чийгтэй цэвэрлэгээ хийнэ.
- 11.5 Онгоцонд гар халдвартгүйжүүлэх бодисыг зорчигчид хэрэглэхэд хүрэлцэхүйц хэмжээгээр байрлуулах, хэрэглээнд хяналт тавьж ажиллана.
- 11.6 Сэжигтэй болон халдварт авсан зорчигч зорчсон тохиолдолд уг онгоцоор зорчсон үед онгоцны агаар шүүх филтер, хоолны үлдэгдэл, аяга таваг, ариун цэврийн

өрөөний хог хаягдал, хамгаалах хувцас хэрэглэлийг халдвартгуйжүүлсний дараа хог хаягдал устгах журмын дагуу устгана.

- 11.7 Сэжигтэй болон халдвар авсан зорчигчийн ачаа тээш, гар цүнхийг халдвартгуйжүүлнэ. Халдвартгуйжүүлэх уусмал болон халдвартгүйтгэлийн бодистой зориулалтын сальфеткаар арчина.

Халдвартгүйтгэлийн бодисыг найруулах арга

| № | Халдвартгуйжүүлэх бодисын нэр | Ажлын уусмал | Халдвартгүйтгэлийн бодисын орох хэмжээ | Уусмалын хувь | Хугацаа | Халдвартгүйтгэх талбай |
|---|--|--------------|--|---------------|---------|---|
| 1 | Клорсепт | 5 л | 1 ш | 0,02% | 1 цаг | Шал, хаалганы бариул гэх мэт хатуу гадаргуу |
| | | 2 л | 1 ш | 0,05% | 1 цаг | Ариун цэврийн өрөө, угаалтуур, суултуур |
| 2 | Жавелион (урьдчилан сэргийлэх зорилгоор) | 10 л | 1 ш | 0,015% | 1 цаг | Шал, хаалганы бариул гэх мэт хатуу гадаргуу |
| | | 10 л | 2 ш | 0,03% | 1 цаг | Ариун цэврийн өрөө, угаалтуур, суултуур |
| 3 | Жавелион (Сэжигтэй тохиолдол болон өвчний голомтод) | 10 | 4 ш | 0,06% | 1 цаг | Шал, хаалганы бариул гэх мэт хатуу гадаргуу, Ариун цэврийн өрөө, угаалтуур, суултуур |
| | | | | | | |
| 4 | Гипохлорид кальци /хуурай/ | - | 400гр/л | - | 1 цаг | Шингэн хаягдал(Бохир ус) |
| 4 | 75%-ийн спирт | 1л | 780 мл (96%) спирт+220 мл ус | 75% | 1 цаг | Нүдний шил халдвартгүйтгэх |

Арван хоёр. Суудлын болон ачааны галт тэрэг, чингэлэгт

- 12.1 Галт тэрэгний машинист болон бусад үйлчилгээнд ажиллах ажилчид нэг удаагийн амны хаалт тогтмол зүүж, 3 цаг тутам сольж битүү таглаатай хогийн саванд хаяж устгалд оруулна.
- 12.2 Чийгтэй цэвэрлэгээг өдөрт 3-аас доошгүй удаа хийнэ.
- 12.3 Гал тэрэгний дотор хэсэг, цонх, хана, суудал, ор, шал, хаалганы бариул, жолооны хүрд гэх мэт хүний гар хүрэх бүх гадаргуу, дугуй, шат, ариун цэврийн өрөө, хогийн сав зэргийг халдвартгүйтгэлийн уусмалаар арчих, эсвэл шүршинэ. Шүршиж хэрэглэсэн тохиолдолд 1 цаг болсны дараа чийгтэй цэвэрлэгээ хийнэ.
- 12.4 Гар халдвартгуйжүүлэх бодисыг зорчигчид хэрэглэхэд хүрэлцэхүйц хэмжээгээр байрлуулах, хэрэглээнд хяналт тавьж ажиллана.
- 12.5 Сэжигтэй тохиолдолд хоолны үлдэгдэл, аяга таваг, ариун цэврийн өрөөний хог хаягдал, хамгаалах хувцас хэрэглэлийг халдвартгуйжүүлсэний дараа хог хаягдал устгах журмын дагуу устгах.
- 12.6 Сэжигтэй тохиолдолд зорчигчийн ачаа тээш, гар цүнхийг халдвартгуйжүүлнэ.
- 12.7 Халдвартгуйжүүлэх уусмал болон халдвартгүйтгэлийн бодистой зориулалтын сальфеткаар арчина.

- 12.8 Сэжигтэй болон халдварт авсан зорчигчийн хэрэглэсэн цагаан хэрэглэл, зөвлөн эдлэлийг халдвартайжүүлнэ. Халдвартайжүүлэлтэд 0.06%-ийн жавелионы уусмалд 30 минут халдвартайжүүлэх эсвэл дэзкамерт 85-90 хэмд 45 минут халдвартайтгэнэ.
- 12.9 Ачааны галт тэрэг болон чингэлгийг 0.06%-ийн жавелионы уусмалаар шүршиж халдвартайжүүлнэ.

Халдвартайтгэлийн бодисыг найруулах арга

| № | Халдвартайжүүлэх бодисын нэр | Ажлын уусмал | Халдвартайтгэлийн бодисын орох хэмжээ | Уусмалын хувь | Хугацаа | Халдвартайтгэх талбай |
|---|---|--------------|---------------------------------------|---------------|---------|--|
| 1 | Клорсепт | 5 л | 1 ш | 0,02% | 1 цаг | Шал, хаалганы бариул гэх мэт хатуу гадаргуу |
| | | 2 л | 1 ш | 0,05% | 1 цаг | Ариун цэврийн өрөө, угаалтуур, суултуур |
| 2 | Жавелион (урьдчилан сэргийлэх зорилгоор) | 10 л | 1 ш | 0,015% | 1 цаг | Шал, хаалганы бариул гэх мэт хатуу гадаргуу |
| | | 10 л | 2 ш | 0,03% | 1 цаг | Ариун цэврийн өрөө, угаалтуур, суултуур |
| | Жавелион (Сэжигтэй тохиолдол болон өвчний голомтод) | 10 | 4 ш | 0,06% | 1 цаг | Шал, хаалганы бариул гэх мэт хатуу гадаргуу, Ариун цэврийн өрөө, угаалтуур, суултуур |
| 3 | Гипохлорид кальци /хуурай/ | | 400гр/л | | 1 цаг | Шингэн хаягдал(Бохир ус) |
| 4 | 75%-ийн спирт | 1л | 780 мл(96%) спирт+220 мл ус | 75% | 1 цаг | Нүдний шил халдвартайтгэх |

Арван гурав. Шалган нэвтрүүлэх цэгт халдвартайжүүлэлт хийх

- 13.1. Шалган нэвтрүүлэх хэсэгт ажиллах ажилтан нэг удаагийн амны хаалт тогтмол зүүж, 3 цаг тутам сольж битүү таглаатай хогийн саванд хаяж, нэгдсэн устгалд оруулах;
- 13.2. Чийгтэй цэвэрлэгээг өдөрт 3-аас доошгүй удаа хийх
- 13.3. Шалган нэвтрүүлэх хэсгийн цонх, шал, хаалганы бариул, хогийн сав гэх мэт хүний гар хүрэх бүх гадаргууг халдвартайтгэлийн уусмалаар арчих, эсвэл шүрших
- 13.4. Цонхыг 2 цаг тутамд нээж агаар сэлгэлт хийх
- 13.5. Шүршиж хэрэглэсэн тохиолдолд 1 цаг болсны дараа чийгтэй цэвэрлэгээ хийх
- 13.6. Гар халдвартайжүүлэх бодисыг хүрэлцэхүйц хэмжээгээр байрлуулах, хэрэглээнд хяналт тавих
- 13.7. Сэжигтэй болон халдварт авсан зорчигчийн ачаа тээш, гар цүнхийг халдвартайжүүлнэ. Халдвартайжүүлэх уусмал болон халдвартайтгэлийн бодистой зориулалтын сальфеткаар арчиж халдвартайжүүлэх.
- 13.8. Сэжигтэй болон халдварт авсан зорчигчийн тээврийн хэрэгслийг 0.06%-ийн жавелионы уусмалаар шүршиж халдвартайжүүлэх.
- 13.9. Тээврийн хэрэгсэлд халдвартайжүүлэлт хийхдээ хаалга цонхыг хаах.
- 13.10. Эхлээд тээврийн хэрэгслийн гадна тал, дугуй хаалгыг шүршинэ. Дараа нь хаалгыг нээж гаднаас дотогш чиглэлээр халдвартайтгэлийн уусмалыг нэвт шүрших.
- 13.11. Халдвартайжүүлэлт хийснээс хойш 1 цагийн дараа чийгтэй цэвэрлэгээ хийнэ.

Арван дөрөв.Халдвартгүйжүүлэлт хийхэд анхаарах зүйл

- 13.12. Халдвартгүйжүүлэлт хийж буй ажилтан маск зүүж, ахуйн бээлий өмсөнө.
- 13.13. Ажлын уусмал бэлтгэхдээ паалантай болон хуванцар таглаатай сав хэрэглэнэ.
- 13.14. Жавелион нь шахмал хэлбэртэй, усанд сайн уусдаг бөгөөд уусмал нь тунгалаг бага зэрэг хлорлог үнэртэй, 20-30 хэмийн бүлээн усанд найруулна.
- 13.15. Халдвартгүйжүүлэлт хийж байгаа үедээ тамхи татах, хоол идэх, уухыг хориглоно.
- 13.16. Халдвартгүйжүүлэх уусмалаар шүршиж халдвартгүйжүүлэлт хийсэн үед халдвартгүйжүүлэлт хийснээс хойш 1 цагийн дараа агаар оруулж чийгтэй цэвэрлэгээ хийнэ.
- 13.17. Цэвэрлэгээнд хэрэглэсэн алчуур, хувин багаж хэрэгслийг 0,03% халдвартгүйтгэх уусмалд 30 минут байлгасны дараа цэвэр усаар сайтар зайлж хатаана.
- 13.18. Халдвартгүйжүүлэлтэд хэрэглэж байгаа бодисыг эм, хүнсний бүтээгдэхүүн, хүүхдийн дэргэд хадгалахгүй, үйлдвэрээс гаргасан буюу битүүмжилсэн таглаатай саванд хадгална.
- 13.19. Хэт мэдрэг харшилтай бол халдвартгүйтгэлийн бодисыг болгоомжтой хэрэглэнэ.
- 13.20. Халдвартгүйжүүлэлтэнд 2 өөр төрлийн бодисыг зэрэг хэрэглэж болохгүй.
- 13.21. Халдвартгүйжүүлэх уусмалыг өдөр бүр шинээр найруулж хэрэглэнэ.
- 13.22. Коронавируст халдварьн сэжигтэй болон батлагдсан тохиолдол бүртгэгдсэн тохиолдолд эрүүл мэндийн байгууллага өвчлөлийн голомтыг цомтгон дараах ариутгал, халдвартгүйжүүлэлтийн үйл ажиллагааг зохион байгуулна.